

Аудитын код: САГ-2017/134/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 262071, 99017100 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Хонгорзул

Аудитор: Б.Долгоржав


Аудитор: Г.Жавхлан

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	«management_zurchil1»	
3.2	«management_zurchil2»	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр, Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230, E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn	ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ДАВААСҮРЭН ТАНАА
2017.02.23 № 3/300 танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газраас аудит хийв. Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ. Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ. Санал дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитаар Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн. Зөрчилгүй санал дүгнэлт Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна. САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ \\10.10.10.20\Bichig_Kherem\Yawsan_Bichig\2017\0223\SA6.Docx	

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аудитын тайланг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 02 сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Долгоржав, Г.Жавхлан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцааны яамны аппаратын удирдлага төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай

хуулинд заасан цаглабарт хугацаанаас ажлын 8 хоног хожимдуулан 02 дугаар сарын 07-нд төрийн аудитын байгууллагад 08/831 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гадаад хэргийн яамны эрхэм зорилго нь Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчинг бүрдүүлэхэд оршиж байна.

Дипломат албаны тухай хуулийн хүрээнд Монгол Улсын гадаад харилцааг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх үйл ажиллагааг тууштай үргэлжлүүлэх зорилтуудыг удирдлага болгон ажилласан байна.

Гадаад харилцааны яамны аппаратын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Гадаад харилцааны яамны аппаратын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Дипломат албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаад харилцааны яамны аппаратын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аудитын төлөвлөлтийн явцад Гадаад харилцааны яамны аппаратын санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог сайн гэж үнэлсэн ба гүйцэтгэл, тайлагналын үед дахин хянахад хэвийн байна.

Гадаад харилцааны яамны аппаратын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Сайн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Гадаад харилцааны яамны аппарат санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн “Axplorer” програм хангамж ашиглажээ.

Гадаад харилцааны яамны аппаратын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ба Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Гадаад харилцааны яамны аппаратын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин дундажаас доогуур байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитын багийн гаргасан шийдэлтэй холбоотой юм.

Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 30.1 тэрбум төгрөг бөгөөд түүний 2 хувь 602.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг тогтоох явцад шинж чанарын болон орчин нөхцлийн зөрчил илэрсэнгүй.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 2 горим, сорил, мөн гүйцэтгэлийн үе шатанд нэмж 7 горим сорил хэрэгжүүлж түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	4,947.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	100.4	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	5	5,047.8	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав. Үүнд:

1. ГХЯ-ны аппарат нь өмнөх оноос авлагын дүнг 95.2 сая, өр төлбөрийн дүнг 256.1 сая төгрөгөөр барагдуулж ажилласан боловч 2016 оны санхүүгийн тайланд нийт 561.0 сая төгрөгийн авлага, ХХОАТ-т 13.4 сая, байгууллага, хувь хүмүүст өгөх 87.5 сая, нийт 100.9 сая төгрөгийн өр төлбөрийг толилуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

2. Тус яамны аппарат тайлант онд 6.2 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *“Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө”, УСНББОУС 12- Бараа материал гэсэн стандарт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс ...”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

3. Батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч цэвэр бохир усны зардлыг 10.8 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 6.8 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 63.6 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараахь заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

1. Гадаад томилолтын зардлаас Говь-Алтай аймагт томилолтоор ажиллах тээвэр шатахууны зардал гэж хэн ямар ажлаар явсан нь тодорхойгүй, томилолтын төсөв гаргаж батлуулаагүй, тушаал шийдвэргүй 9.1 сая, зочид буудлын зардалд 1.9 сая, 10 сэтгүүлч, зураглаачийн томилолтын зардалд 1.7 сая, сайдын гадаадад томилолтоор ажиллах холбооны зардалд 2.9 сая, УИХ-ын АБГББХ-ны гишүүдэд хүндэтгэлийн зоог, бэлэг дурсгалд 2.4 сая, бэлэг дурсгалын зардалд 6.5 сая төгрөгийг илүү зарцуулсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 6.4.2-т *"төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"*, ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ын 2.4-т *"Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 65.0 мянган төгрөгөөс ... илүүгүй үнэтэй зүйл байхаар ..."* гэсэн заалтуудтай, ГХЯ-ны Сайд, ТНБД нарын гадаадад томилолтоор ажиллах нислэгийн тийзийг 1 дүгээр зэрэглэлийн ангиллаар тооцож улсын төсвөөс 75.9 сая төгрөг хэмнэх боломжийг алдсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх алдаа зөрчлийн давтан гаргахгүй ажиллах талаар 100.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэх

2. ГХЯ-ны "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилга угсралтын ажлын нээлттэй тендерт "ХӨ МО ТЭ" ХХК шалгарч, 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор ашиглалтад оруулахаар гэрээ байгуулан, 2013 оноос нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан боловч одоог хүртэл барилга ашиглалтад ороогүй, санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй явж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.2.7-д *"гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, хариуцлага тооцож ажиллах"*, Гадаад харилцааны яам, "ХӨМОТЭ" ХХК-ийн хооронд 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан "Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний барилгын талбай чөлөөлөх, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ"-ний 5-д *"Гүйцэтгэгч нь ... 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад оруулах"* гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Гадаад харилцааны сайдын төсвийн багцын санхүүгийн аудит хийх хугацаанд АСЕМ зохион байгуулахтай холбогдон ГХЯ-ны аппаратын зардлаас зарцуулсан хөрөнгийг шалгаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэнэ.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гадаад харилцааны яам өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 26.3 тэрбум төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	26,343.19	24,692.50	6.2	1,651.29
1.1	Урсгал зардал	26,343.19	24,371.32	7.5	1,971.87
1.2	Хөрөнгийн зардал	0.0	321.1	0.0	321.1

Төсөвт зардлыг 6.2 хувиар хэмнэсэн нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэнтэй холбоотой байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Гадаад харилцааны яамны аппарат Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад алдаа зөрчил илэрсэнгүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Гадаад харилцааны яамнаас 2017 оны 02 сарын 20-ны өдрийн 14/1115 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаад харилцааны яамны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаад харилцааны яамны аппаратын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 АВЛАГА, ӨР ТӨЛБӨР

Илрүүлэлт

ГХЯ-ны аппарат нь өмнөх оноос авлагын дүнг 95.2 сая, өр төлбөрийн дүнг 256.1 сая төгрөгөөр барагдуулж ажилласан боловч 2016 оны санхүүгийн тайланд нийт 561.0 сая төгрөгийн авлага, ХХОАТ-ын 13.4 сая, байгууллага, хувь хүмүүст өгөх 87.5 сая, нийт 100.9 сая төгрөгийн өр төлбөрийг толилуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”* гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Авлага, өр төлбөрийг барагдуулж ажиллах

Хариуцах ажилтан

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Байгалмаа

Эрсдэл

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 ЗАРДАЛ

Илрүүлэлт

Тус яамны аппарат тайлант онд 6.2 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *“Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө”*, УСНББОУС 12-Бараа материал, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.15-д *“Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс ...”* гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Байгалмаа

Эрсдэл

Холбогдох хууль эрх зүйн акт, стандарт зөрчигдөх, бараа материалын тайлан буруу илэрхийлэгдэх

Зөвлөмж

Холбогдох хууль эрх зүйн акт, стандартыг мөрдөж ажиллах, бараа материалыг нягтлан бодох бүртгэлийн тооцооны дансаар дамжуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 ЗАРДАЛ

Илрүүлэлт

Батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч цэвэр бохир усны зардлыг 10.8 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 6.8 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 63.6 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”* гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Байгалмаа

Эрсдэл

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

Зөвлөмж

Төсвийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, батлагдсан зардлын хүрээнд зардал гаргах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 ДУУСААГҮЙ БАРИЛГА

Илрүүлэлт

3. ГХЯ-ны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга угсралтын ажлын нээлттэй тендерт “ХӨ МО ТЭ” ХХК шалгарч, 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор ашиглалтад оруулахаар гэрээ байгуулан, 2013 оноос нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан боловч одоог хүртэл барилга ашиглалтад ороогүй, санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй явж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2.7-д *“гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, хариуцлага тооцож ажиллах”*, Гадаад харилцааны яам, “ХӨМОТЭ” ХХК-ийн хооронд 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний барилгын талбай чөлөөлөх, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-ний 5-д *“Гүйцэтгэгч нь ... 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад оруулах”* гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Байгалмаа

Эрсдэл

Холбогдох гэрээ, хууль эрх зүйн акт зөрчигдөх, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохгүй байх

Зөвлөмж

Барилгыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

- 4.1** Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2** Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3** Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4** Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5** Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,493,666,170.75</u>	<u>1,174,421,892.02</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,000,299.79	197,135.69
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	30,991,299.79	188,135.69
31110	Төгрөг	20,239,926.79	188,135.69
31120	Гадаад валют	10,751,373.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,000.00	9,000.00
3121	Төгрөг	9,000.00	9,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	9,000.00	9,000.00
33	АВЛАГА	656,267,068.22	561,088,032.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,793,780.63	387,421.16
335	Бусад авлага	641,473,287.59	560,700,610.94
3351	Байгууллагаас авах авлага	561,411,489.88	480,638,813.23
3352	Хувь хүмүүсээс авах авлага	80,061,797.71	80,061,797.71
34	УРЬДЧИЛГАА	96,649,982.18	96,649,982.18
34600	Урьдчилж гарсан зардал	96,649,982.18	96,649,982.18
35	БАРАА МАТЕРИАЛ	709,748,820.56	516,486,742.05
351	Түүхий эд материал	659,332,475.20	467,437,947.69
35110	Тусгай зориулалттай материал	659,332,475.20	467,437,947.69
354	Хангамжийн материал	50,416,345.36	49,048,794.36
35410	Бичиг хэргийн материал	5,805,242.00	3,506,492.00
35420	Аж ахуйн материал	188,000.00	
35460	Хүнсний материал		784,680.00
35470	Бусад хангамжийн материал	44,423,103.36	44,757,622.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,658,639,768.17</u>	<u>6,772,083,751.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,658,639,768.17	6,772,083,751.76
391	Газар		
392	Биет хөрөнгө	6,516,514,246.92	6,647,733,582.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,527,138,414.46	1,527,138,414.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	-185,966,714.43	-211,419,021.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,612,201,397.58	1,695,748,423.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-669,109,399.20	-886,308,991.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	830,221,463.39	891,213,583.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-511,575,238.90	-578,045,475.25
39209	Зам, гүүрийн байгууламж	461,082,045.02	461,082,045.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	-456,861,229.00	-461,058,904.17
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,797,135.00	3,797,135.00

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,897,470,299.00	4,197,470,299.00
39217	Ном	8,116,074.00	8,116,074.00
393	Биет бус хөрөнгө	142,125,521.25	124,350,169.29
39301	Програм хангамж	187,064,418.80	187,064,418.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-44,938,897.55	-62,714,249.51
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,152,305,938.92</u>	<u>7,946,505,643.78</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>356,950,456.14</u>	<u>100,851,340.21</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	356,950,456.14	100,851,340.21
413	Өглөг	356,950,456.14	100,851,340.21
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,262,248.32	13,399,277.74
4136	Бусад өглөг	353,688,207.82	87,452,062.47
41361	Байгууллагад төлөх өглөг	351,241,483.42	85,005,338.07
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,446,724.40	2,446,724.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,795,355,482.78</u>	<u>7,845,654,303.56</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,795,355,482.78	7,845,654,303.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,354,882,602.25	2,354,882,602.25
51101	Өмч: - төрийн	2,354,882,602.25	2,354,882,602.25
512	Хуримтлагдсан үр дүн	5,326,175,371.98	5,376,474,192.76
51210	Өмнөх үеийн үр дүн	5,326,175,371.98	5,326,175,371.98
51220	Тайлант үеийн үр дүн		50,298,820.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	114,297,508.55	114,297,508.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,152,305,938.92</u>	<u>7,946,505,643.77</u>

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,199,398,989.67	30,186,322,795.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,248,662,333.56	1,630,109,830.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,209,225,022.56	1,630,109,830.70
120002	Хүүгийн орлого	707,240.46	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,208,517,782.10	1,630,109,830.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,208,517,782.10	1,619,410,042.62
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10,699,788.08
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	39,437,311.00	0.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	39,437,311.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,950,736,656.11	28,556,212,964.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,950,736,656.11	25,770,045,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,186,741,244.11	25,547,264,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,500,000,000.00	
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	263,995,412.00	222,781,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,184,967,764.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,184,967,764.89
1330	Төсвийн захирагчдаас	0.00	601,200,000.00
133003	Хөрөнгийн		601,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,317,321,264.90	30,136,303,704.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,817,321,264.90	30,136,303,704.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,918,541,016.77	25,096,711,289.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,691,722,635.82	2,497,976,246.23
210101	Үндсэн цалин	1,691,722,635.82	2,497,976,246.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,567,510.67	224,485,858.44
210201	Тэтгэврийн даатгал	201,567,510.67	223,909,858.44
210202	Тэтгэмжийн даатгал		576,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,327,298.00	113,387,735.00
210301	Гэрэл, цахилгаан	33,971,768.00	32,476,210.00
210302	Түлш, халаалт	43,023,392.00	55,055,351.00
210303	Цэвэр, бохир ус	9,332,138.00	21,578,974.00

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210304	Байрны түрээс		4,277,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	191,310,637.20	94,722,265.82
210401	Бичиг хэрэг	162,792,859.80	74,295,020.72
210402	Тээвэр, шатахуун	8,727,600.00	3,541,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,011,077.40	16,213,803.10
210404	Ном, хэвлэл	779,100.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		672,242.00
2105	Нормативт зардал	0.00	128,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		128,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,804,790.00	9,699,600.00
210604	Урсгал засвар	7,804,790.00	9,699,600.00
2107	Томилолт, зочны зардал	870,147,272.89	903,134,606.26
210701	Гадаад албан томилолт	740,093,875.19	567,179,042.50
210702	Дотоод албан томилолт		320,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	130,053,397.70	335,635,563.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,772,068.00	12,357,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,921,900.00	
210807	Газрын төлбөр	850,168.00	12,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		37,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,753,888,804.19	21,240,818,177.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,792,375.70	20,702,992,303.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	815,000.00	223,454,620.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	310,281,428.49	314,371,254.49
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,898,780,248.13	5,039,592,415.16
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,031,198,708.25	1,671,905,868.20
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,031,198,708.25	1,671,905,868.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	214,393,623.22	319,255,256.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	119,893,731.22	229,738,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,499,892.00	89,516,651.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,652,522,817.26	3,048,431,290.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,652,522,817.26	3,048,431,290.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	665,099.40	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	665,099.40	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,500,000,000.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	2,500,000,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-117,922,275.23	50,019,091.08

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	279,729.70
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		279,729.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,286,241.16	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,909,900.71	
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,376,340.45	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,286,241.16	279,729.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-123,208,516.39</u>	<u>50,298,820.78</u>

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,747,767,569.43	30,548,923,646.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,618,788,307.18	1,632,710,681.48
120	Нийтлэг татварын бус орлого	1,618,788,307.18	1,632,710,681.48
120002	Хүүгийн орлого	707,240.46	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,618,081,066.72	1,632,710,681.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,618,081,066.72	1,581,955,539.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		50,755,141.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,128,979,262.25	28,916,212,964.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,950,736,656.11	25,770,045,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,186,741,244.11	25,547,264,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,500,000,000.00	
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	263,995,412.00	222,781,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	178,242,606.14	2,544,967,764.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	178,242,606.14	2,544,967,764.89
1330	Төсвийн захирагчдаас	0.00	601,200,000.00
133003	Хөрөнгийн		601,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,282,170,888.10	30,162,974,400.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,282,170,888.10	30,162,974,400.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,822,327,238.02	24,809,837,869.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,658,025,995.77	2,470,513,634.36
210101	Үндсэн цалин	1,552,984,995.77	2,359,165,034.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	105,041,000.00	111,348,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,950,603.81	158,917,400.33
210201	Тэтгэврийн даатгал	188,950,603.81	158,917,400.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,327,298.00	113,387,735.00
210301	Гэрэл, цахилгаан	33,971,768.00	32,476,210.00
210302	Түлш, халаалт	43,023,392.00	55,055,351.00
210303	Цэвэр, бохир ус	9,332,138.00	21,578,974.00
210304	Байрны түрээс		4,277,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,003,777.40	78,633,553.10
210401	Бичиг хэрэг	22,486,000.00	57,459,550.00

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210402	Тээвэр, шатахуун	8,727,600.00	3,541,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,011,077.40	17,632,803.10
210404	Ном, хэвлэл	779,100.00	
2105	Нормативт зардал	0.00	128,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		128,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,694,830.00	10,091,490.00
210602	Тавилга	35,890,040.00	
210604	Урсгал засвар	7,804,790.00	10,091,490.00
2107	Томилолт, зочны зардал	769,812,249.20	888,608,175.70
210701	Гадаад албан томилолт	644,449,860.60	549,990,496.50
210702	Дотоод албан томилолт		320,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	125,362,388.60	338,297,679.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,772,068.00	12,357,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,921,900.00	
210807	Газрын төлбөр	850,168.00	12,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		37,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,908,740,415.84	21,077,199,080.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,907,925,415.84	20,853,158,460.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	815,000.00	224,040,620.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,459,843,650.08	5,353,136,531.16
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,116,198,708.25	1,671,905,868.20
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,116,198,708.25	1,671,905,868.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	215,740,128.00	319,199,886.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	121,240,236.00	229,727,485.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,499,892.00	89,472,401.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,127,239,714.43	3,352,668,481.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,127,239,714.43	3,352,668,481.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	665,099.40	9,362,295.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	665,099.40	9,362,295.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,465,596,681.33</u>	<u>385,949,246.20</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,500,000,000.00	417,032,140.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000,000.00	417,032,140.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,500,000,000.00	417,032,140.00
222001	Тоног төхөөрөмж	2,500,000,000.00	

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		417,032,140.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,500,000,000.00	-417,032,140.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	1,376,340.34	-279,729.70
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	1,376,340.34	-279,729.70
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,376,340.34	279,729.70
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-35,779,659.01	-30,803,164.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,779,958.80	31,000,299.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,000,299.79	197,135.69

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,326,175,371.98		7,795,355,482.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,326,175,371.98	0.00	7,795,355,482.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,326,175,371.98	0.00	7,795,355,482.78
D01	2016 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,326,175,371.98	0.00	7,795,355,482.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,326,175,371.98	0.00	7,795,355,482.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			50,298,820.78		50,298,820.78
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,354,882,602.25	114,297,508.55	5,376,474,192.76	0.00	7,845,654,303.56

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,343,196,400.00	24,692,507,242.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,343,196,400.00	24,371,322,242.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,231,838,700.00	22,383,162,773.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,900,708,800.00	1,900,708,800.00
210101	Үндсэн цалин	1,789,360,200.00	1,789,360,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	111,348,600.00	111,348,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,917,400.00	158,917,400.00
210201	Тэтгэврийн даатгал	98,775,700.00	158,917,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,865,600.00	113,387,735.00
210301	Гэрэл, цахилгаан	36,906,300.00	32,476,210.00
210302	Түлш, халаалт	68,912,100.00	55,055,351.00
210303	Цэвэр, бохир ус	10,720,800.00	21,578,974.00
210304	Байрны түрээс	4,326,400.00	4,277,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,517,600.00	52,858,303.10
210401	Бичиг хэрэг	24,863,500.00	31,684,300.00
210402	Тээвэр, шатахуун	8,500,600.00	3,541,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,153,500.00	17,632,803.10
2105	Нормативт зардал	169,200.00	128,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	169,200.00	128,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,064,800.00	13,143,390.00
210604	Урсгал засвар	15,064,800.00	13,143,390.00
2107	Томилолт, зочны зардал	730,889,100.00	730,457,195.08
210701	Гадаад албан томилолт	587,329,500.00	523,690,496.50
210702	Дотоод албан томилолт	718,400.00	320,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	142,841,200.00	206,446,698.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,320,000.00	12,357,900.00
210807	Газрын төлбөр	12,320,000.00	12,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		37,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,239,386,200.00	19,401,203,150.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,237,219,200.00	19,399,036,150.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,167,000.00	2,167,000.00

Гадаад харилцааны яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,111,357,700.00	1,988,159,469.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,786,449,800.00	1,671,905,868.20
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,786,449,800.00	1,671,905,868.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	324,907,900.00	316,253,601.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	235,349,100.00	226,781,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,558,800.00	89,472,401.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	321,185,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	321,185,000.00
222001	Тоног төхөөрөмж		321,185,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,903,196,400.00	24,357,466,887.56
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,343,196,400.00	22,775,231,618.04
131001	Улсын төсвөөс санхүүжих	26,119,196,400.00	22,552,450,418.04
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	224,000,000.00	222,781,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	560,000,000.00	1,582,235,269.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000,000.00	1,581,955,539.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		279,729.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		